
Responsible Mining Index 2018

Рио Тинто (Rio Tinto)

Company report



Рио Тинто

LSE: RIO

NYSE: RIO

ASX: RIO

Компанийн удирдлагын төв байр:

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Австралийн Холбооны Улс

Салбар:

Олон төрлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг

Төрийн эзэмшил:

Төрийн эзэмшил байхгүй

Татварын өмнөх орлого (\$ ам. доллар, тэрбумаар):

33.781 (31/12/2016)

Ажилчдын тоо:

Тайлагнаагүй


Ажилчдын тоо (үндсэн ажилтан + гэрээт ажилтан):

51,018 (31/12/2016)

Компаниас мэдээлсэн уурхайн ажилчдын үйлдвэрлэлийн ослын улмаас нас баралтын тоо:

2015 | ажилчид: 5

2016 | ажилчид: 7



Компанийн удирдлага байрладаг улс орнууд

Компанийн уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй улс орнууд

Уул уурхайн талбарын түвшний үнэлгээнд сонгогдсон уурхайн талбарууд

Summary Results


Рио Тинто компани нь Эдийн Засгийн Хөгжил, Бизнесийн Ёс Зүй, Хөдөлмөрийн Нөхцөл, Байгаль Орчны Хариуцлага гэх 4 салбарт өндөр үзүүлэлт гаргаснаар хамгийн хүчтэй үр дүн бүхий 10 компанийн нэг болсон байна. “Эдийн засгийн хөгжил” салбарт үндэсний ур чадварын баазыг сайжруулах, уул уурхайн ойролцоох орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд системчилсэн байдлаар хандаж ирсэн нь баримт, нотолгоогоор харагдаж байна. Бизнесийн ёс зүйн салбарт, Рио Тинто Компанийн албан ёсны үйл ажиллагааны үүрэг амлалтад авилга, хээл хахуулиас ангид байх, эрдэс баялагийн орлогыг ил тод болгох тухай заалтууд орсон байна. (Компани бизнесийн ёс зүйг баримтлах албан ёсны үүрэг амлалт хүлээсэн харин ямар үйл ажиллагаа явуулж тус үүрэг амлалтаа хэрэгжүүлсэн талаар мэдээлэл хомс байна). Түүнчлэн, Рио Тинто компани нь үндэсний хэмжээнд засгийн газар, түүний харьяа засаг захиргааны байгууллагууд болон уурхайн түвшинд орон нутагт хийсэн төлбөрийн мэдээллээ нээлттэй болгосон зарим нотолгоо байна.

“Хөдөлмөрийн нөхцөл” салбарт, Рио Тинто компани хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх үүрэг амлалтаа бодит ажил хэрэг болгож, үр дүнг нь эргэн хянасан нотолгоо гаргасан байна. “Байгаль Орчны Хариуцлага” салбарт, тус компанийн гаргасан хамгийн сайн үзүүлэлт нь системтэйгээр байгаль орчны үр нөлөөг шатлан бууруулах үүрэг амлалт хүлээсэн бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө болон хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Гэсэн хэдий ч, нийтэд нь авч үзвэл Рио Тинто компанийн гаргасан үр дүн хязгаарлагдмал байгаа ба энэ нь орон нутгийн иргэдийн сайн сайхан байдалтай холбоотой асуудалд системтэйгээр анхаарал хандуулж байгаа нотолгоо дутмаг байсантай холбоотой. Жишээлбэл, тус компани хүний эрхтэй холбоотой асуудлыг хэрхэн удирдаж буй, нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдтэй харилцах харилцааны чанарт эргэн дүгнэлт хийх, эсвэл уурхайн харуул хамгаалалтыг хангахтай холбогдон болзошгүй хүний эрхийн зөрчил, халдлага гарахаас сэргийлэх ажлын үзүүлэлтээ эргэн хянахтай холбоотой ямар ч нотолгоо олдоогүй болно.



Эдийн засгийн хөгжил



0.223 / 1.000




Бизнесийн зарчим



0.630 / 1.000




Уурхайн төслийн мөчлөгийн удирдлага



0.254 / 1.000



Орон нутгийн иргэдийн сайн сайхан байдал



0.214 / 1.000




Ажиллах нөхцөл, орчин



0.570 / 1.000



Байгаль орчны хариуцлага




0.447 / 1.000


Хамгийн дээд дүн болох 1.000 оноо нь бүх компаниудын үр дүнг харгалзан тухайн салбарын бүх индикаторын үзүүлэлтээр авсан хамгийн сайн онооны нийлбэр юм. Хамгийн сайн онооны нийлбэр нэг салбараас нөгөө салбарт харилцан адилгүй байгаа учир доорх график зургийг тухайн компанийн үзүүлэлтийг салбар хооронд харьцуулахад ашиглах боломжгүй юм.

Бүх компаниудын үзүүлсэн үр дүн олон нийтэд нээлттэй мэдээллээс ХУУИ-ийн шинжээчдийн цуглуулсан эсвэл компаниас өөрөөс нь ирүүлсэн баримт мэдээлэлд суурилсан. Цөөн тооны компанийн хувьд боломжит мэдээлэл маш хомс байсан. Бага оноо авсан нь тухайн компанийн олон нийтэд нээлттэй баримт бичиг дунд ач холбогдол бүхий мэдээлэл байгаагүйгээс шалтгаалсан байж болохыг тэмдэглэх нь зүйтэй.


Холбогдох компанийн үзүүлэлт



Үүрэг амлалт (11
Индикаторууд)



Үйлдэл, арга хэмжээ (41
Индикаторууд)



Үр нөлөө (21
Индикаторууд)

1.00 – тухайн хэмжиж буй салбарын бүх индикаторуудын хамгийн сайн онооны нийлбэр


ИНДИКАТОРУУДЫН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ



Эдийн засгийн хөгжил


A.01 ҮНДЭСНИЙ БОЛОН БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

A.01.1 Компани нь уурхайн төсөл хэрэгжиж буй улсын нийгэм эдийн хөгжлийг дэмжих зорилгоор уул уурхайн хөрөнгө оруулалт, бизнесийн шийдвэр гаргахдаа тухайн улсын үндэсний болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтийг харгалзан үзэх үүрэг амлалт хүлээнэ.



A.02 ХУДАЛДАН АВАЛТ

A.02.1 Компани нь үндэсний хэмжээнд болон өргөн хүрээнд бүс нутгийн түвшин дэх нийлүүлэгч нарт худалдан авалтын боломжуудыг олгох, хөгжүүлэх тогтолцоотой байна.




A.02. 2 Компани нь худалдан авалтын гүйцэтгэлийг хянан бүртгэж, үнэлгээний үр дүнд үндэсний болон бүсийн түвшинд худалдан авалтын боломжуудыг нэмэгдүүлнэ.




A.03 ЧАДАВХИ БИЙ БОЛГОХ

A.03.1 Компани нь уул уурхайгаас үүдэлтэй нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх үндэсний чадавхыг бий болгох, Судалгаа Хөгжлийг дэмжих тогтолцоотой байна.



A.04 ҮНДЭСНИЙ УР ЧАДВАРЫН БААЗЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

A.04.1 Компани нь бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон дахь өөрийн үйл ажиллагаандаа мэргэжлийн, дунд болон удирдах түвшинд ур чадвар хөгжүүлэх, дамжуулах тогтолцоотой байна.







Бизнесийн зарчим

В.01 БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

В.01.1 Компани нь бизнесийн ёс зүйг мөрдөж ажиллахыг өөрийн бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгоно.




В.01.2 Компани нь үйл ажиллагааныхаа бүхий л салбарт аливаа ёс зүйгүй үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авдаг, үр ашигтай ажиллах механизмтай байна.




В.02 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ДЭЭД ТҮВШНИЙ УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГА

В.02.1 Компани эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа явуулах үүрэг хариуцлагыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон дээд түвшний менежерүүдэд оногдуулах тогтолцоотой байна.




B.02.2 Компани нь төлөөлөн удирдах зөвлөл болон дээд түвшний удирдлагад олон талт байдал, ялгаатай үзэл санаа, бодолтой хүмүүсийн оролцоог дэмжинэ.




B.03 CONTRACTS DISCLOSURE

B.03.1 Компани эрдэс баялаг олборлолт, байгалийн баялгийг ашиглах болон холбогдох бусад төслийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан бүхий л гэрээ хэлэлцээр, лиценз тусгай зөвшөөрлийг ил болгох ба шаардлагатай тохиолдолд засгийн газрыг ижил дүрэм баримтлан гэрээний ил тод байдлыг хангахыг шаардана.



B.04 ТАТВАРЫН ИЛ ТОД БАЙДАЛ

B.04.1 Компани нь үйл ажиллагаа явуулж буй татварын бүс нутаг бүрд татварын ил тод байдлыг ханган ажиллана.




B.05 АШИГ ХҮРТЭГЧ ЖИНХЭНЭ ЭЗЭД (БЕНЕФИЦИАР ӨМЧЛӨГЧ)

В.05.1 Компани нь өөрийн бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өмчилдөг компаниуд эрдэс баялаг олборлох зорилгоор тендерт оролцсон, олборлох салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, эсхүл хөрөнгө оруулалт хийсэн бол тухайн компани бүрийнхээ ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг олон нийтэд ил болгоно.




В.06 УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЯВАГДАЖ БУЙ УЛС ОРНУУДАД ӨГЧ БУЙ ТӨЛБӨРҮҮД

В.06.1 Компани нь үндэсний Засгийн газар, аймаг дүүргийн засаг захиргааны байгууллагад төлсөн бүх төлбөрийн мэдээллийг уул уурхайн төсөл бүрээр гаргаж нийтэд ил болгоно.




В.07 ХУУЛЬ ТОГТООМЖИД НӨЛӨӨЛӨХ, БОДЛОГОД ОРОЛЦОХ

В.07.1 Компани нь хууль тогтоомжид нөлөөлөх арга барил, байр сууриа нийтэд ил болгоно.




В.07.2 Компани нь уул уурхайн орлого, орлогын хуваарилалт болон зарцуулалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор талуудын оролцоог хангасан форумд идэвхтэй, үр дүнтэй оролцоно.




В.08 АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛЬ

В.08.1 Компани нь шууд болон шууд бус бүхий л хэлбэрийн авилга, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх үүрэгтэй.




В.08.2 Компани нь авилга, хээл хахуулийн эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа хянан бүртгэж, үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн шууд, шууд бус хэлбэрийн авилга, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, сайжруулна.



В.09 ХАРИУЦЛАГАТАЙ ГЭРЭЭ ХИЙХ, БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ


В.09.1 Компани нь гэрээ байгуулагч, дэд гэрээ байгуулагч, ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааны практикийг тогтмол хянан судалж, байгаль орчин, нийгэм, засаглал болон хүний эрхийн эрсдэлийг тогтоох, үнэлэх тогтолцоотой байна.






С.01 УУРХАЙН ТӨСЛИЙН МӨЧЛӨГИЙН УДИРДЛАГА

С.01.1 Компани нь уул уурхайн төсөл хэрэгжих бүхий л хугацааны турш уул уурхайн мөчлөгийн удирдлагын арга барилыг үйл ажиллагааны үе шат бүрд мөрдөж ажиллана.



С.01.2 Компани нь уул уурхайн төслийн үйл ажиллагаанд гарах томоохон өөрчлөлтийн үед (жишээлбэл, барилга байгууламж барьж дуусаад олборлолтын үе шатруу шилжих, эсвэл цомхтгох үед) ажилчдад үзүүлж буй нийгэм-эдийн засгийн нөлөөллийг зохицуулах үйл ажиллагаагаа эргэн хянаж гарсан үр дүнд нь үндэслэн ажилчдын шилжилт зүй ёсны дагуу явагдах нөхцөлийг тогтмол сайжруулах арга хэмжээ авна.




С.02 ТӨСӨЛ БАТЛУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

С.02.1 Компани нь уурхайн төслийн үе шат бүрд байгаль орчин, нийгэм, засаглал, хүний эрх зэрэг хүчин зүйлүүдийг хөрөнгө оруулалтын зөвлөлийн түвшинд нэгтгэн оруулах тогтолцоотой байна.




С.03 УУЛ УУРХАЙН ХААЛТЫН ДАРААХ ОРОН НУТГИЙН ИРГЭД, АЖИЛЧДЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОМЖ


С.03.1 Компани нь газрын нөхөн сэргээлтийг хийх бөгөөд газрыг цаашид ашиглах боломжуудын талаар төлөвлөгөө хийх тогтолцоотой байна.




С.03.2 Компани нь уурхайн хаалтын дараах нутгийн иргэд рүү чиглэсэн шилжилтийн үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлэх замаар нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааны боломж, амьдрах нөхцөлийг баталгаажуулна.



С.03.3 Компани нь уурхайн хаалтын дараах ажилчид руу чиглэсэн шилжилтийн үйл ажиллагаа төлөвлөж, ажилчдыг уурхайн эргэн тойрон болон өөр газар ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэн тэдний цаашдын амьжиргааны боломжийг баталгаажуулна.



С.03.4 Компани уурхайн хаалт болон хаалтын дараах хариуцлагыг хангах санхүүгийн баталгааг гаргах бөгөөд үйл ажиллагааныхаа бүх түвшинд тухайн санхүүгийн баталгааны мэдээллийг нийтэд ил болгоно.



С.04 КОМПАНИЙН НЭГДЭН НИЙЛЭХ, ӨӨРТӨӨ КОМПАНИ НЭГТГЭХ, ТУСГААРЛАХ (САЛГАХ) АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

С.04.1 Компани нь Компанийн нэгдэн нийлэх, Компанийг өөртөө нэгтгэх, тусгаарлах (салгах) асуудлаар дүн шинжилгээ хийхдээ өмнөх, одоогийн болон ирээдүйн хөгжилд гарч болзошгүй эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглал, хүний эрхийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх тогтолцоотой байна.


	дунд 1.02
0.00	
	ИХ 6.00




Орон нутгийн иргэдийн сайн сайхан байдал

D.01 ХҮНИЙ ЭРХ


D.01.1 Компани нь өөрийн ажилчид болон нутгийн иргэдийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах зорилгоор НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Талаар Баримтлах Зарчмууд-д нийцсэн хүний эрхийг хүндэтгэх үүргийг хүлээсэн байна.



D.01.2 Компани нь НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Талаар Баримтлах Зарчмууд-д нийцүүлэн өөрийн үйл ажиллагаандаа тогтмол дүн шинжилгээ хийж, хүний эрхэд онцгой нөлөөлөл байгаа эсэхийг тогтоож үнэлэх бөгөөд нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах стратеги, төлөвлөгөө хэрэгжүүлэх замаар ажилчдын болон орон нутгийн иргэдийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах тогтолцоотой байна.



D.01.3 Компани нь НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Талаар Баримтлах Зарчмууд-ын дагуу Хүний эрхийн асуудлыг өөрийн үйл ажиллагааны удирдлага, гүйцэтгэлд хэрхэн тусган хэрэгжүүлж буй талаар нийтэд тайлагнана.




D.01.4 Компани нь хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хүндэтгэх, өөрийн үйл ажиллагааны талбарт тэдэнд хамгаалалт үзүүлэх үүрэг амлалттай байна.




D.02 ИРГЭДИЙН БОЛОН ТАЛУУДЫН ОРОЛЦОО

D.02.1 Компани нь уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд, эмэгтэйчүүд, залуучуудыг хамруулан, тэдний амьдралд нөлөөлж болзошгүй асуудлаар хэлэлцүүлэг болон шийдвэрт оролцуулах бүтэц, тэдний оролцоог хангасан байнгын харилцааг дэмжих болон хялбарчлах тогтолцоотой байна.



D.02.2 Компани нь уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдтэй тогтоосон харилцааны чанарт хяналт тавьж, цаашид харилцаагаа итгэлцэл, харилцан хүндэтгэл, ойлголцол дээр үндэслэн тогтмол сайжруулна.



D.03 ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БОЛОМЖ


D.03.1 Компани нь өөрийн үйл ажиллагааны нийгэм эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг тогтмол нийтэд ил болгох бөгөөд тухайн нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд, эмэгтэйчүүд, залуучууд болон бусад иргэдийн оролцоог хангаж ажиллах тогтолцоотой байна.




D.03.2 Компани нь орон нутгийн хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих, орон нутгийн бизнес хөгжил, эмэгтэйчүүд, залуучууд болон бусад иргэдийн бараа үйлчилгээ нийлүүлэх бизнест тусламж, дэмжлэг өгч ажиллахыг баталгаажуулах тогтолцоотой байна.



D.03.3 Компани нь хүүхдүүдэд, үүнд албан ёсны хараа хяналтгүй, эрх ашиг нь аливаа байгууллагаар төлөөлөн хамгаалагдах боломжгүй хүүхдүүдийг хамруулан компанийн үйл ажиллагаа тэдэнд хэрхэн нөлөөлж буй талаарх үнэлгээг тогтмол хийн олон нийтэд ил болгох тогтолцоотой байна.




D.03.4 Компани нь орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхийн тулд Компанийн зүгээс удирдан зохион байгуулж буй нийгэм эдийн засгийн үйл ажиллагааг тогтмол хянан сайжруулах арга хэмжээ авч ажиллана.



D.04 НУТГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

D.04.1 Компани өөрийн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж буйг тогтмол үнэлэн ил болгох тогтолцоотой байх ба тэдгээр нөлөөллийг шийдвэрлэх удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.




D.05 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

D.05.1 Компани нь эмэгтэйчүүдэд үзүүлж буй аливаа уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг хянан бүртгэж, нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтмол авч, эмэгтэйчүүдийг дэмжин ажиллана.




D.06 УУГУУЛ ИРГЭД

D.06.1 Боломжтой тохиолдолд, компани нь одоогийн болон ирээдүйд төлөвлөсөн уурхай, уурхайн барилга байгууламжийн нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн уугуул иргэдийн оролцоотойгоор тэдний эрх, ашиг сонирхол, хэрэгцээ, хэтийн төлөвийг тодорхойлж, мөн эдгээрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, тогтолцоотой байна.




D.06.2 Боломжтой тохиолдолд, компани нь орон нутгийн уугуул иргэдийн эрх, ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл, соёл болон иргэдийн байгалийн нөөцөд тулгуурласан амьжиргааг хүндэтгэн үзэж одоогийн болон ирээдүйд төлөвлөсөн уурхай, уурхайн бусад барилга байгууламжийн нөлөөллийг байнга хянан бүртгэж аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, иргэдийн тогтвортой үр ашиг, боломж нөхцөлийг хангаж ажиллана.




D.07 ЧӨЛӨӨТЭЙГӨӨР, МЭДЭЭЛЛЭЭР УРЬДЧИЛАН ХАНГАГДСАНЫ ҮНДСЭН ДЭЭР ЗӨВШИЛЦӨЛД ХҮРЭХ

D.07.1 Компани нь уугуул иргэдийн “чөлөөтэйгөөр, мэдээллээр урьдчилан хангагдсаны үндсэн дээр зөвшилцөлд хүрэх” эрхийг хүндэтгэх, нөлөөлөлд өртсөн бусад нутгийн иргэдэд энэхүү зарчмын дагуу хандах үүрэг амлалт хүлээсэн байна.




D.08 ГАЗАР АШИГЛАЛТ, НҮҮЛГЭН СУУРЫШУУЛАЛТ


D.08.1 Компани нь хамтын газар ашиглах боломж, бололцоог тодорхойлж үнэлэх, эдгээр боломжуудыг оновчтой болгохын сацуу сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах, бууруулах арга хэмжээ, стратегийг хэрэгжүүлэх тогтолцоотой байна.



D.08.2 Компани нь төсөлтэй холбоотой нөлөөлөлд өртсөн хүмүүсийн, үүнд эмэгтэйчүүд болон залуучуудыг хамруулан, тэдний оролцоотойгоор нүүлгэн шилжүүлэлтийн болзошгүй биет хөрөнгийн болон эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, улмаар нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах, бууруулах стратеги, төлөвлөгөө хэрэгжүүлэх тогтолцоотой байна.



D.08.3 Компани нь нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг хянан бүртгэж, иргэдийн амьжиргаа, амьжиргааны баталгаат байдал, амьдралын чанар стандартыг дээшлүүлэх, эсвэл хэвээр нь хадгалахад нь анхаарч, энэ үйл ажиллагааг тогтмол сайжруулна.




D.09 БИЧИЛ УУЛ УУРХАЙ

D.09.1 Боломжтой тохиолдолд, компани нь өөрийн үйл ажиллагаандаа бичил уурхайчидтай эртнээс харилцаа тогтоож, идэвх санаачилга гарган дэмжин ажиллах тогтолцоотой байна.




D.09.2 Боломжтой тохиолдолд, компани нь бичил уурхай эрхлэгчдэд үйл ажиллагааны тусламж дэмжлэг үзүүлэх, амьжиргааны өөр эх үүсвэртэй болгох хөтөлбөрт хамруулах тогтолцоотой байна.




D.10 АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОРОН НУТАГ ДАХЬ ЗӨРЧИЛ

D.10.1 Компани уурхайн харуул хамгаалалт, аюулгүй байдлын удирдлагатай холбоотой үүсэж болзошгүй хүний эрхэнд халдах эрсдэлийг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулан үр дүнг нь хянах бөгөөд “Аюулгүй Байдал ба Хүний Эрхийн Сайн Дурын Зарчим”-ын дагуу тухайн эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээг тогтмол сайжруулна.




D.10.2 Компани нь өөрийн үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, зөрчилтэй эсвэл өндөр эрсдэлтэй газар ажилчдад болон нутгийн иргэдэд учирч болох эрсдэлийг тогтоож үнэлэх, эдгээр эрсдэлийг шийдвэрлэх арга зам, стратегийг хэрэгжүүлэх тогтолцоотой байна.



D.11 ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ЗАЛРУУЛАХ


D.11.1 Компани нь нутгийн иргэдэд зориулсан гомдол хүлээн авах, залруулах механизмын үйл ажиллагааг хянан бүртгэж, нэхэмжлэгчийн гомдлыг үр дүнтэй залруулахад тогтмол анхаарч ажиллана.





Е.01 АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ТҮВШИНД ХҮРСЭН ЦАЛИН ХӨЛС

Е.01.1 Компани олгож буй цалин хөлсний хэмжээгээ хянан судалж, түүндээ үндэслэн амьжиргааны баталгаажих түвшинд хүрсэн эсвэл хуулиар тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний аль илүүд нь нийцсэн болон түүнээс дээгүүр цалин хөлс олгоход үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан ажиллана.



Е.02 ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА (ХЭААА)


Е.02.1 Компани нь аюулгүй, эрүүл ахуйн нөхцөлийг хангасан ажлын байраар хангах үүрэгтэй.



Е.02.2 Компани нь эмэгтэй ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тусгай хэрэгцээг хангах үйл ажиллагааны тогтолцоотой байна.




Е.02.3 Компани нь өөрийн үйл ажиллагаандаа ХЭААА хэрэгжилтийг хянаж, бүртгэж, ажлын байрны эрүүл, аюулгүй байдлыг хангахад тогтмол анхаарч сайжруулна.



Е.03 ХОЛБОО БАЙГУУЛАХ,ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХ ЭРХ БОЛОН ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Е.03.1 Компани нь өөрийн үйл ажиллагаандаа ажилчдын эвлэлдэн нэгдэх, холбоо байгуулах, холбоогоор дамжуулан ажлын цалин хөлс, нөхцөлийн талаар зөвшилцөх, эрхийг хүндэтгэх тогтолцоотой байна.




Е.04 АЖИЛЧДЫН САНАЛ ГОМДОЛ БАРАГДУУЛАХ

Е.04.1 Компани нь өөрийн ажилчдад зориулсан гомдол хүлээн авах, залруулах бүтцээ хянан бүртгэж, нэхэмжлэгчийн гомдлыг үр дүнтэй залруулахад тогтмол анхаарч ажиллана.




Е.05 ҮЛ ЯЛГАВАРЛАХ, ИЖИЛ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ

Е.05.1 Компани нь хөдөлмөрийн харилцааны суурь зарчимд үндэслэн ижил тэгш боломж олгох, бүх төрлийн ялгаварлан гадуурхах хэлбэрийг устгах, түүнчлэн ажлын байр дахь олон талт байдлыг хөхиүлэн дэмжих тогтолцоотой байна.



Е.06 АЛБАДАН БОЛОН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ УСТГАХ

Е.06.1 1 Компани нь өөрийн үйл ажиллагаа, нийлүүлэлтийн гинжин хэлхээг бүхэлд нь хянан судалж, болзошгүй бүх хэлбэрийн албадан болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүний наймааны эрсдэлийг олж тогтоох, үнэлэх бөгөөд эдгээр эрсдэлийг бууруулах, устгах стратегийг хэрэгжүүлэх тогтолцоотой байна.







Байгаль орчны хариуцлага

F.01 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ


F.01.1 Компани нь байгаль орчны нөлөөллийг үе шаттайгаар бууруулах арга барилыг ашиглан хэрэгжүүлэх үүрэгтэй.



F.01.2 Компани нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээг нэгдсэн аргаар тогтмол хийж, үр дүнг ил болгоно.




F.01.3 Компани нь байгаль орчны нөлөөллийг бууруулах үйл ажиллагаагаа хянан бүртгэж, нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах асуудалд тогтмол анхаарч сайжруулна.



F.02 УУРХАЙН ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГА

F.02.01-Боломжтой тохиолдолд, компани нь уурхайн хог хаягдлын барилга байгууламжаас үүдэх шингэн хог хаягдлын шүүрэл, хаягдлын далан нурах, аваар осол гарах гэх мэт болзошгүй эрсдэлийг удирдах үйл ажиллагаагаа хянан бүртгэж, эдгээр эрсдэлээс зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах, бууруулахад тогтмол анхаарч сайжруулна.




F.03 АГААР

F.03.1 Компани нь уул уурхайн төслийн бүхий л хугацааны турш уурхай орчмын агаарын чанарт мониторинг хийж, үр дүнг нийтэд нээлттэй байлгана.




F.04 УС

F.04.1 Компани нь үйл ажиллагааныхаа ойр байрлах голын сав газар эсвэл, усны нөөц газрын усны чанар, хэмжээнд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, усны нөөцийг зөв зохистой ашиглах, хэмнэх, хамгаалах стратеги төлөвлөгөө хийж хэрэгжүүлэх, түүнчлэн уурхайн нөлөөлөлд байгаа хүрээлэн буй орчин, орон нутгийн иргэд, газар тариаланч, болон бусад ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн усны хэрэгцээ, эрхийг хүндэтгэх тогтолцоотой байна.




F.04.2 Компани нь усны удирдлагын хүрээнд усны чанар, хэмжээг хянан бүртгэж, өөрийн үйл ажиллагаандаа усны хэрэглээ, усны чанарт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад тогтмол анхаарч ажиллаж, тухайн сав газрын бусад усны оролцогч талуудын усны аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулна.




F.05 ДУУ ЧИМЭЭ, ЧИЧИРГЭЭ

F.05.1 Компани нь дуу чимээ, чичиргээнээс нутгийн иргэд, барилга, байгууламж, зэрлэг амьтдад үзүүлж буй нөлөөллийг судлах, дуу чимээ, чичиргээг хязгаарлах үйл ажиллагааны тогтолцоотой байна.




F.06 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

F.06.1 Компани нь Дэлхийн Өвд бүртгэлтэй талбарт хайгуул болон олборлолт явуулахгүй байх бөгөөд соёлын болон байгалийн өвийг хадгалах зорилготой хуурай газрын болон далайн тусгай хамгаалалттай газруудыг хүндэтгэх үүрэгтэй.




F.06.2 Компани нь биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд үзүүлж буй нөлөөллийг хянан бүртгэж, нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах, бууруулах бөгөөд дүйцүүлэн хамгаалахад тогтмол анхаарч ажиллана.




F.07 ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГ


F.07.1 Компани нь цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй нөхцөл байдал нь уул уурхайн үйл ажиллагаа, нутгийн иргэд, ажилчид, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг олж тогтоох, тухайн нөхцөл байдалд дасан зохицох стратегийг боловсруулан хэрэгжүүлэх тогтолцоотой байна.



F.07.2 Компани нь уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хий үйлдвэрлэлийг анхааралдаа авч, хянан судалж хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээнд гарч буй өөрчлөлт дэвшлийг батлан харуулна.




F.07.3 Компани нь үйл ажиллагаандаа зарцуулж буй эрчим хүчний хэмжээг хянан судалж, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.




F.08 АЮУЛТАЙ МАТЕРИАЛЫН УДИРДЛАГА

F.08.1 Компани нь аюултай материалыг тээвэрлэх, зөөх, хадгалах, устгах, зайлуулахад гарч болзошгүй эрсдэлийг олж тогтоох, үнэлэх; эрсдэлийг бууруулах стратеги төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх тогтолцоотой байна.




F.09 ОНЦГОЙ БАЙДЛЫН БЭЛЭН БАЙДАЛ

F.09.1 Компани нь онцгой байдлын үед бэлэн байх үүднээс орон нутгийн засаг захиргаа, өөрийн ажилчид, нутгийн иргэдийг оролцуулан авах арга хэмжээ, хариу үйлдлийн төлөвлөгөөг хамтран боловсруулах, турших тогтолцоотой байна.



F.09.2 Компани нь онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор гамшигтай тэмцэх, буцаан сэргээхэд зориулсан санхүүгийн баталгааны талаарх бүх мэдээллийг нийтэд ил болгоно.



Сонгогдсон уул уурхайн талбарын үр дүн

Бие даасан үнэлгээ хийгдсэн боловч Компанийн нийт оноонд тусгагдаагүй уурхайн талбарууд

Уул уурхайн талбарын нэр	Орон нутгийн худалдан авалт (оноо /6.00)	Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт (оноо /6.00)	Орон нутгийн иргэдийн гомдол хүлээн авах, залруулах механизм (оноо /6.00)	Ажилчдын гомдол гаргах механизм (оноо /6.00)	Усны чанар болон тоон хэмжээ (оноо /6.00)	Биологийн олон янз байдлын удирдлага (оноо /6.00)	Mine site (score /6.00)
<u>Oyu Tolgoi</u>	5	2	6	6	6	6	5.17
<u>QIT Madagascar Minerals</u>	0	0	0	0	0	0	0.00
<u>Richards Bay Minerals</u>	5	2	3	2	3	4	3.17
<u>Rössing</u>	3	2	0	0	3	2	1.67

Уул уурхайн бүх талбарын нэрсийн жагсаалт

Уул уурхайн талбарын нэр Өөр нэр Улс орон Компанийн хувьцаа (%) Бүтээгдэхүүнүүд Уурхайн төрлүүд

Уул уурхайн талбарын нэр	Өөр нэр	Улс орон	Компанийн хувьцаа (%)	Бүтээгдэхүүнүүд	Уурхайн төрлүүд
Argyle		Австралийн Холбооны Улс	100	Алмазны сорьц	Open-pit, Underground
Boron		Америкийн Нэгдсэн Улс	100	Борийн хүчлийн давс	
Coal & Allied		Австралийн Холбооны Улс	100	Нүүрс	
Dampier Salt operations	Dampier, Port Hedland, Lake MacLeod	Австралийн Холбооны Улс	68	Давс	
Diavik		Канад улс	60	Алмазны сорьц	Далд уурхай
Energy Resources of Australia	Ranger, Jabiluka	Австралийн Холбооны Улс	68.4	Ураны исэл	
Escondida (Rio Tinto)*		Бүгд Найрамдах Чили улс	30	Зэс, алт, мөнгө	Ил уурхай
Gove		Австралийн Холбооны Улс	100	Хөнгөн цагааны хүдэр / боксит	Ил уурхай
Hail Creek		Австралийн Холбооны Улс	82	Нүүрс	Ил уурхай
Hamersley iron mines	Broackman, Broackman no. 4, Channar, Eastern Range, Marandoo, Mount Tom Price, Nammuldi, Paraburdoo, Western Turner Syncline, Yandicoogina	Австралийн Холбооны Улс	100	Төмрийн хүдэр	
Hope Downs mines	Hope Downs 1, Hope Downs 4	Австралийн Холбооны Улс	50	Төмрийн хүдэр	
Hunter Valley		Австралийн Холбооны Улс	67.6	Нүүрс	Ил уурхай
IOC mine	Carol Lake	Канад улс	58.7	Төмрийн хүдэр	

Уул уурхайн талбарын нэр	Өөр нэр	Улс орон	Компанийн хувьцаа (%)	Бүтээгдэхүүнүүд	Уурхайн төрлүүд
Kennecott		Америкийн Нэгдсэн Улс	100	Зэс, Алт, Молибден	
Kestrel		Австралийн Холбооны Улс	80	Нүүрс	Далд уурхай
Mount Thorley		Австралийн Холбооны Улс	80	Нүүрс	Ил уурхай
Oyu Tolgoi		Монгол Улс	33.5	Зэс, алт, мөнгө	Ил уурхай
QIT Madagascar Minerals		Бүгд Найрамдах Мадагаскар Улс	80	Титан	Ил уурхай
Richards Bay Minerals		Бүгд Найрамдах Өмнөд Африк Улс	74	Титан, Төмрийн хүдэр, Циркони	Ил уурхай
Rio Tinto Fer et Titane (RTFT)		Канад улс	100	Титан, Төмрийн хүдэр, Циркони	
Robe River mines	Mesa J, Mesa A, West Angelas	Австралийн Холбооны Улс	53	Төмрийн хүдэр	
Rössing		Бүгд Найрамдах Намиб Улс	68.6	Ураны исэл	Ил уурхай
Warkworth		Австралийн Холбооны Улс	55.57	Нүүрс	Ил уурхай
Weipa		Австралийн Холбооны Улс	100	Хөнгөн цагааны хүдэр / боксит	Ил уурхай

Хаагдсан уурхайн талбарууд (уурхайн хаалт, хаалтын дараах хөрөнгө арчилах, засварлах удирдлагын хяналтад байдаг).

Уул уурхайн талбарын нэр	Өөр нэр	Улс орон	Компанийн хувьцаа (%)	Бүтээгдэхүүнүүд	Уурхайн төрлүүд	Уурхайн хаалт хийсэн он
Flambeau		Америкийн Нэгдсэн Улс	100	Зэс	Ил уурхай	1997
Kelian		Индонез улс	90	Алт	Ил уурхай	2006
Ridgeway		Америкийн Нэгдсэн Улс	100	Алт, Мөнгө	Ил уурхай	1999

Assets sold during the assessment period

Уул уурхайн талбарын нэр	Өөр нэр	Улс орон	Бүтээгдэхүүнүүд	Уурхайн төрлүүд
Bengalla		Австралийн Холбооны Улс	Нүүрс	
Mount Pleasant		Австралийн Холбооны Улс	Нүүрс	
Murowa		Зимбаб улс	Алмазны сорьц	Далд уурхай
Zululand Anthracite Colliery		Бүгд Найрамдах Өмнөд Африк Улс	Нүүрс	

Үндсэн хувьцаа эзэмшигчид

(09/02/2018 оны байдлаар)	Хувьцаа (%)
Aluminum Corp of China Ltd	13.64
BlackRock Institutional Trust Company, N.A.	9.54
Capital World Investors	2.76
The Vanguard Group, Inc.	2.35
Legal & General Investment Management Ltd.	2.11
Aberdeen Asset Investments Limited	1.51
Capital Research Global Investors	1.45
JPMorgan Asset Management U.K. Limited	1.25
M & G Investment Management Ltd.	1.19
State Street Global Advisors (UK) Ltd.	1.08
Standard Life Investments Ltd.	1.05

SAFE Investment Company Limited	1.02
---------------------------------	------

Aviva Investors Global Services Limited	1
---	---

BlackRock Investment Management (UK) Ltd.	0.97
---	------

UBS Asset Management (Switzerland)	0.92
------------------------------------	------

Мэдэгдэж буй татварын бүс нутаг

Аруба арал	Австралийн Холбооны Улс	Бельгийн Вант Улс	Бермудын арал	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс	Британий Виржиний Арал
Канад улс	Бүгд Найрамдах Чили улс	Бүгд Найрамдах Хятад Улс	Бүгд Найрамдах Кипр Улс	Бүгд Найрамдах Финланд Улс	Бүгд Найрамдах Франц Улс
Бүгд Найрамдах Габон Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Бүгд Найрамдах Гвиней Улс	Хонг Конг, БНХАУ	Исланд Улс	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
Индонез улс	Бүгд Найрамдах Итали улс	Япон Улс	Жерси арал	Бүгд Найрамдах Казахстан Улс	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс
Люксембургийн Их Бэйст Улс	Бүгд Найрамдах Мадагаскар Улс	Малайз Улс	Бүд Найрамдах Мальт Улс	Бүд Найрамдах Маврики Улс	Мексикийн Нэгдсэн Улс
Монгол Улс	Мароккын Вант Улс	Бүгд Найрамдах Мозамбик Улс	Бүгд Найрамдах Намиб Улс	Нидерландын Вант Улс	Шинэ Зеланд Улс
Оманы Султант Улс	Бүгд Найрамдах Панам Улс	Папуа Шинэ Гвинейн Тусгаар Улс	Бүгд Найрамдах Перу Улс	Бүгд Найрамдах Филиппин Улс	Оросын Холбооны Улс
Бүгд Найрамдах Серб Улс	Бүгд Найрамдах Сингапур Улс	Бүгд Найрамдах Өмнөд Африк Улс	Бүгд Найрамдах Солонгос Улс	Испанийн Вант Улс	Шведийн Вант Улс

Швейцарын Холбооны Улс	Бүгд Найрамдах Турк Улс	Арабын Нэгдсэн Эмират улс	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	Америкийн Нэгдсэн Улс	Бүгд Найрамдах Венесуэл Улс
---------------------------	-------------------------------	---------------------------------	--	--------------------------	-----------------------------------

Бүгд Найрамдах
Замби Улс

**Хөрөнгө оруулагч/ Төр хоорондын хөрөнгө оруулалтын талаарх маргаанд холбогдсон байдал
(2014 оноос хойш)**

Хэрэг байхгүй

Disclaimer

The findings, conclusions and interpretations within this 2018 Responsible Mining Index (RMI) report do not necessarily represent the views of funders, trustees, and employees of the Responsible Mining Foundation, and others who participated in consultations and as advisors to the report.

This report is intended to be for information purposes only and is not intended as promotional material in any respect. The report is not intended to provide accounting, legal, tax or investment advice or recommendations, neither is it intended as an offer or solicitation for the purchase or sale of any financial instrument. In order to fully understand the methodology of the 2018 Responsible Mining Index, the respective sections on the website should be consulted.

The RMI seeks evidence of companies' policies and practices on economic, environmental, social and governance (EESG) issues, but does not seek to measure the actual outcomes achieved on EESG issues. Results are based only on evidence sourced from the public domain or provided by companies as open data. Whilst this information is believed to be reliable, no guarantee can be given that it is accurate or complete, nor does it preclude the possibility that policies and practices may exist, but which the RMI has not been able to consider for purposes of assessment. In this respect, the results of the low-scoring companies do not necessarily reflect a lack of relevant policies and practices; as they may be due to a lack of public reporting by the companies, limitations in accessing information, and/or any difficulties in accessing the RMI company portal.

It should be noted that, prior to publication, all companies in the Index were invited to check the factual accuracy of the contextual data and evidence upon which the Index is based and to review company information in the RMI document library.

Although every effort has been made to verify the accuracy of translations, the English language version should be taken as the definitive version. The RMI reserves the right to publish corrigenda on its web page, and readers of the 2018 RMI report should consult the web page for corrections or clarifications <https://www.responsibleminingindex.org>.



www.responsibleminingindex.org